



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 1166

Дархан

Тамхи худалдан борлуулах энгийн
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх заалт, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, Засгийн газрын 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам”-ын 5.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 52 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангасан 8 дугаар Ардын өргөн чөлөө, 4 дүгээр гудамжны 408 дугаар байрны А тоотод үйл ажиллагаа явуулдаг “Түмэн Ёндоо” ХХК-ийн “Амирлан” мини маркетын тамхи худалдан борлуулах энгийн зөвшөөрлийг 3 жилээр олгосугай.

2.Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг энгийн зөвшөөрөл авсан “Түмэн Ёндоо” ХХК-ийн “Амирлан” хүнсний дэлгүүрийн захирал (А.Тэмүүлэн)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Худалдаа үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн (С.Шинэзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Т.ТУЛГАА

4525010534

D.ajil.Zahiramj-2025